



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

┌ Үндэсний соёл, амралтын хүрээлэнгийн ┐  
бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх  
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.19 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.7 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндэсний соёл, амралтын хүрээлэнгийн бүтээн байгуулалтын ажлыг нийслэл Улаанбаатар хотын иргэд, оршин суугчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн эрчимжүүлэх зорилгоор "Үндэсний соёл, амралтын хүрээлэн" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хооронд "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулах саналыг дэмжсүгэй.

2. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-г даалгасугай.

2.1. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан "Хамтран ажиллах гэрээ"-г 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор байгуулж, хэрэгжилтийг хангах;

2.2. "Үндэсний соёл, амралтын хүрээлэн" ХХК-ийн эзэмшилд байгаа 10.2 га газрыг холбогдох хуулийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нэр дээр шилжүүлэн авч, зөвхөн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн зориулалтаар ашиглах нөхцөлийг бүрдүүлэн тохижуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шуурхай зохион байгуулах;

2.3. Энэ тогтоолын 2.2 дахь хэсэгт заасан газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай асуудлыг 2022 оны III улиралд багтаан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

3. Бүх насны хүмүүст зориулсан амралт, зугаалгын цогцолбор, соёл, амралтын хүрээлэн, тоглоом, олон нийтийн соёл, спорт, урлагийн үйлчилгээ үзүүлэх, арга хэмжээг зохион байгуулах боломжийг бүрдүүлж, төслийн бүтээн байгуулалтын актыг эрчимжүүлэн 2024 онд багтаан дуусгахыг "Үндэсний соёл, амралтын хүрээлэн" ХХК-ийн хөрөнгө оруулагч, удирдлагад үүрэг болгосугай.

1110100271

4 Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хот байгуулалт, дэд бүтцийн хороо (Б.Сүхбаатар)-нд даалгасугай.



ДАРГА

Ж.БАТБАЯСГАЛАН